



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН З А Х И Р А М Ж

2018 оны 6 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Концессын тухай хуулийн хэрэгжилтийн явцад дүгнэлт хийж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- | | |
|----------------------|--|
| Ахлагч | -Монгол Улсын Шадар сайд. |
| Гишүүд: | -Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх;
-Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Засгийн газрын ахлах референт;
-Үндэсний хөгжлийн газрын дарга;
-Үндэсний хөгжлийн газрын Концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн албаны дарга;
-Үндэсний хөгжлийн газрын Концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн албаны ахлах мэргэжилтэн;
-Үндэсний хөгжлийн газрын Концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн албаны мэргэжилтэн. |
| Нарийн бичгийн дарга | -Үндэсний хөгжлийн газрын Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга. |

2. Концессын тухай хуулийн хэрэгжилтийн явцын талаарх дүгнэлт болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан 3 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшинд даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ